

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ – НИЙГМИЙН ДЭВШИЛ

Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж, хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.1. Эрүүл мэндийн бодлого

1.1.1. Эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангамж, ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

1.1.2. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулна.

1.1.3. “Эрүүл хүүхэд – Шаргын ирээдүй” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

1.1.4. Эрүүл мэндийн явуулын үзлэг, оношилгоог бүх багт жил бүр зохион байгуулна.

1.1.5. Эмнэлгийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэж, лаборатори-оношилгооны болон эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмжийг ээлж дараатай шинэчилнэ.

1.1.6. Багийн эмч нарыг унаагаар бүрэн хангана.

1.1.7. Эмнэлгийн машины парк шинэчлэлт хийнэ.

1.1.8. Иргэдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1.1.9. Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, эмнэлгийн дотоод халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн төвийг стандартын хог хаягдлын цэгтэй болгоно.

1.1.10. Сумын эргэлтийн эмийн санг ажиллуулах журам, түүнд тавих хяналтыг сайжруулна.

1.1.11 Эмнэлгийн орчмыг гэрэлтүүлэгтэй болгож, хайсжуулна.

1.2. Биеийн тамир, спортын бодлого

1.2.1. “Аваргын гараа” хөтөлбөр хэрэгжүүлж, тамирчдыг дэмжиж ажиллана.

1.2.2. Хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцлийг бүрдүүлж, спорт цогцолбор шинээр барина.

1.2.3. Шатрын спортыг хөгжүүлж, бүх нийтийн хүртээл болгоно.

1.3 Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих бодлого

1.3.1. Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлнэ.

1.3.2. Бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэн, цэцэрлэг, соёлын төв, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулан, сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, орчин үеийн дэвшилтэт сургалтын орчинг сумдаа бий болгоно.

1.3.3. Сургуулийн дотуур байранд их засвар хийнэ.

1.3.4. Цэцэрлэг, дотуур байрны хатуу зөөлөн эдлэлийг шинэчилнэ.

1.3.5. Зуны цэцэрлэгийг жил бүр багт ажиллуулна.

1.3.6. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хамран сургалтыг 3-5 хувиар нэмэгдүүлнэ.

1.3.7 Улс, бүс, аймгийн төрөлжсөн олимпиад, багшийн ур чадварын болон илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон багш, сурагчид, элсэлтийн ерөнхий шалгалтанд шавиа амжилттай бэлтгэсэн багшийгурамшуулдаг журмыг баталж хэрэгжүүлнэ.

1.3.8 Суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг нарийвчлан тогтоож, цаашид дээшлүүлэх тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.3.9. Соёлын төвийн хөгжим техник хэрэгслийг шинэчилнэ.

1.3.10. Орон нутаг судлах танхимаар үйлчлүүлэгчдийн болон үзмэрийг тоог нэмэгдүүлнэ.

1.3.11 Боловсрол, соёлын үйлчилгээг хүргэх автобустай болгоно.

1.3.12 Цэцэрлэг сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

1.3.13 Сургуулийн хичээлийн байрны дээврийг их засварт оруулна.

1.3.14. Сургуулийн цахилгааны монтажны асуудлыг шийдвэрлэнэ.

1.3.15. Сургуулийн дотуур байрны дэргэд гүн өрмийн худаг гаргана.

1.3.16. Соёлын төвийг урлагийн хувцас хэрэглэлтэй болгоно.

1.3.17. “Багш, сурагч, эмч, эмнэлгийн ажилтны солилцоо” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3.18. Гэгээрлийн өргөөний үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.3.19. Цэцэрлэгийн хүүхдийн байрны өргөтгөлийг хийнэ.

1.4 Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

1.4.1 Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээ, нийтийг хамарсан ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.4.2 Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг явуулж судалгааны дагуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.

1.4.3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагыг нийгмийн даатгалд бүрэн хамруулна.

1.4.4. Хөдөлмөрийн насны иргэдийн 30-аас доошгүй хувийг сайн дурын даатгалд хамруулна.

1.4.5. Ажилгүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэг, нөхөрлөл, хоршоололд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

1.4.6. Хөдөлмөрийн Е биржийг сумд бий болгоно.

1.4.7. Буудал, гуанз, халуун усыг тогтмол ажиллуулна.

1.5 Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүд, гэр бүлийг дэмжих бодлого

1.5.1 Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана.

1.5.2 Ахмад настан, эмэгтэйчүүдийн хэрэгцээ чадамжинд суурилсан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөтөлбөр боловсруулан байнгын орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.3. Жилд 2-оос доошгүй зөвлөгөөн, чуулганыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

1.5.4. Сумын “Соёлч өрх” -ийг жил бүр шалгаруулдаг болно.

1.5.5. Чийрэгжүүлэлтийн танхимыг байнгын үйл ажиллагаатай болгоно.

1.5.6. Сумын алдартнуудын алдар гавьяаг мөнхжүүлэх, зорилгоор жил бүр тодорхой зохион байгуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлж, ажлын байр бий болгон өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.1. Мал аж ахуйг эрчимжүүлэх, бэлчээрийг хамгаалах талаар

2.1.1. Малжуулах аяныг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай малчин өрхийг эхний ээлжинд хамруулж, мал нийлүүлэх арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалтаар зохион байгуулна.

2.1.2. Мах, сүүний чиглэлийн ашиг шимтэй малын фермерийн аж ахуйг хөгжүүлэх сонирхлыг дэмжиж, үр ашгийг дээшлүүлнэ.

2.1.3. Баг бүрт өвс, тэжээлийн нөөцийн цэгтэй болж, мал аж ахуйг эрсдлээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

2.1.4. Ямааны хээлтүүлэгчийг чанаржуулах замаар ноолуурын чанар гарцыг сайжруулна.

2.1.5. Малчин өрхийн хөдөлмөрийг бүрэн үнэлж, урамшуулах бодлогыг баримталж, малчдын хамтын хөдөлмөрийг дэмжиж ажиллана.

2.1.6. Мал эмнэлэг, үржлийн тасаг, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ

2.1.7. “Эрүүл мал - Эрүүл хүнс” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.1.8. Мал сүргийг байгалийн болзошгүй эрсдэл, гэнэтийн халдлагаас хамгаалах эрсдлийн сантай болох ажлыг эхлүүлнэ.

2.1.9. Орон нутагт малын гоц халдварт өвчин гаргахаас урьдчилан сэргийлж, гаднаас ирж буй малыг лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллана.

2.1.20. Мал эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгах цэгтэй болгоно.

2.1.21. Баянгол, Хамтын хүч багт мал угаалгын ванн барина.

2.1.22. Туслах аж ахуй эрхлэгчдийн хороололтой болгох ажлыг зохион байгуулна.

2.1.23. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдийг төсөл хөтөлбөрт хамруулж материаллаг баазыг сайжруулна.

2.1.24. Тэмээ, үхэр өсгөх бодлогыг дэмжиж ажиллана.

2.1.25. “Шаргын шигшмэл хурд” хурдан морины уралдааныг зохион байгуулна.

2.1.26. Бэлчээрийг зөв зохистой ашиглах БИНХ-ын тогтоол гаргуулж, мөрдүүлнэ.

2.1.27. Бэлчээрийг улирлын хуваарийн дагуу ашиглах, хортон мэрэгчтэй тэмцэх үр ашигтай аргыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.

2.1.28. Бэлчээр ашиглалтын бүлэг, нөхөрлөлийг дэмжиж ажиллана.

2.1.29. Бэлчээрийн ургамлын ажиглалт хийх цэгийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.30. Атаршсан газрыг усжуулах ажлыг зохион байгуулж, хадлангийн талбайн ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.1.31. Бэлчээрийг усжуулах зорилгоор уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.32. Мал нядалгааны цэгийг журмын дагуу ажиллуулж, нэмж тохижуулна.

2.2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх

2.2.1 Арван дөрөвтийн тариалангийн талбайг ашиглаж, үр бордооны шинэчлэл хийж, төмс хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалж, тэжээлийн бага оврын үйлдвэр байгуулна.

2.2.2. Жимс жимсгэнэ, чацарганà, хөх арвайн тариалалтыг нэмэгдүүлж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.2.3. Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийнэ.

2.2.4. Газар тариалан эрхлэгчдийн тоог жил бүр нэмэгдүүлнэ.

2.2.5. Хүнсний ногооны хэрэглээний 70%-ийгдоошгүй дотоодоосоо хангана.

2.2.6. Хүлэмжийн аж ахуйг өргөтгөнө.

2.2.7. “Газрын үр шим-Өрхийн хөгжил” хөтөлбөр боловсруулж ажиллана.

2.3. Бизнес эрхлэлтийг дэмжих

2.3.1. Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжин, стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлж, борлуулалтын сүлжээ бий болгоно.

2.3.2. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулан, ажлын үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.3. Баялаг бүтээгч иргэдийг “Алтай-Түншлэл” үзэсгэлэн худалдаанд оролцуулж, “Өрмөн шаргал говь” үзэсгэлэн худалдааг Нэг өрх - Нэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа болгон өргөжүүлж сумд жил бүр зохион байгуулна.

2.3.4. Малын үзэсгэлэн худалдаг жил бүр зохион байгуулна.

2.3.5. “Эрүүл хүнс-Зөв хоололт” өдөрлөгийг зохион байгуулж, хэвшүүлнэ.

2.4. Төсөл зээлийн таатай орчинг бий болгох

2.4.1. Төсөл хөтөлбөрт өрх бүрийг жигд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.4.2. Орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ-СУМЫН ХӨГЖИЛ

3.1. Эрчим хүчний өргөтгөл, шинэчлэл

3.1.1. Сумын төвийг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий халаалт, цэвэр бохир усны нэгдсэн системтэй болгох асуудлыг судална.

3.1.2. Эрчим хүчний шугам сүлжээнд өргөтгөл хийнэ.

3.2 Сумын хөгжил, газар зохион байгуулалт

3.2.1 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөтэй уялдуулан сумын төвд автозам, гэрэлтүүлэг, замын тэмдэглэгээг хийж гүйцэтгэнэ.

3.2.2. Сумын айл өрх бүрийг хаягжуулах ажлыг хийнэ.

3.2.3. Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

3.2.4. ХААН банкны барилга шинээр барина.

3.3. Багийн хөгжлийг дэмжих талаар

3.3.1. Багуудын утасны сүлжээг сайжруулах ажлыг үүрэн холбооны компаниудтай хамтран зохион байгуулна.

3.3.2. Хамтын хүч, Сондуулт багуудын төвийн байрыг засварлаж, Улаан туг багийн төвийг тохижуулна.

3.3.3. Хөдөө багуудад зам засварлана.

3.3.4. Багийн Засаг дарга нарыг унаажуулна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоож, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.1. Онгон байгалиа хамгаалах

4.1.1. Уул овооны тайлга, тахилгыг уламжлалт ёсны дагуу гүйцэтгэж, уул усаа тахиж, хайрлан хамгаалах үзлийг нийтэд төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.2. Хууль бус ан агнууртай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.3. Орон нутагт эрэл хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой хяналт тавьж ажиллана.

4.1.4. Идэвхтэн байгаль хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжиж, байгаль хамгаалах нөхөрлөлийн тоог нэмэгдүүлнэ.

4.1.5. Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч - хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.

4.1.6. Сумын төвийн ундны усны худгийн тохижилтыг хийж, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтооно.

4.1.7. Гялгар уутны хэрэглээг багасгаж, хог хаягдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.

4.1.8. Хог хаягдал зөөвөрлөх машинтай болгоно.

4.2. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх

4.2.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.

4.2.2. Ан амьтдын нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчийн ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлж, унаагаар хангана.

4.2.3. Байгалийн үзэсгэлэнтэй газрыг түшиглэн сумд аялал жуулчлалын газар байгуулна.

4.3. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж

4.3.1. Сумын төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг бүрэн шийдвэрлэж, “НОГООН ОРЧИН” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

4.3.2. Булаг шандны эхийг хамгаалах зурвас газар байгуулах, моджуулж, ургамалжуулах ажлыг малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран хийж, усны ундаргыг нэмэгдүүлнэ.

4.3.3. Говийн бүсийн модлог, бутлаг ургамлын нөхөн сэргээлтэнд анхаарч ажиллана.

4.3.4. Урд голд биологийн нөхөн сэргээлт хийнэ

4.3.5. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэнэ.

4.3.6. Голын ай сав, цөлжилт, элсний нүүдэл бүхий газруудыг ойжуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ЗӨВ ЗАСАГЛАЛ

5.1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ.

5.1.1. Төрийн албаны ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, нээлттэй шалгаруулалтанд шалгарсан иргэнийг төрийн албанд томилдог зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.

5.1.2. Төсөвт байгууллагуудыг батлагдсан орон тоондоо хэвийн ажиллах боломжийг хангаж, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллана.

5.1.3 Гамшгийн болон батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

5.2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ

5.2.1. Сумын төвийн баг байгуулах асуудлыг судалж уламжилна.

5.2.2. Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагатай хамтран шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

5.2.3. Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, тасралтгүй хүргэнэ.

5.2.4. Цэцэрлэг, Соёлын төвийг архивын зориулалтын өрөөтэй болгоно.

5.2.5. Иргэдээ сонсох нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын мөрөөр бодит ажил зохиож үр дүнг мэдэгдэж хэвшинэ.

5.2.6. Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулж шаардлагатай тоног төхөөрөмж, нийгмийн баталгаагаар хангуулна.

5.2.7. Төрийн албан хаагчийн харьцаа хандлага, ажлын хариуцлага, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг төрийн байгууллага бүр иргэдэд тайлагнадаг болно.

5.2.8. Төрийн албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, давтан болон мэргэшүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

5.2.9. “Тэдний бүтээл-Түмний минь төлөө” ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг сурталчлах, хайрлан хамгаалах, эзэмшил ашиглалтыг сайжруулах талаар иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор баг бүрт хэлэлцүүлэг зохион байгуулна.

5.3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал

5.3.1. Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангана. Үүний тулд шилэн данс, төрийн албаны бусад цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө.

5.3.2. Төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангаж төсвийн болон сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үйл явц, үр дүн, сум байгууллагын түвшинд олон нийтэд мэдээлж тайлагнана.

5.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

5.4.1. Малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болох зорилтыг дэвшүүлж ажиллана.

5.4.2. Хуулийн байгууллагын албан хаагчдын ёс зүйг сахиулж, хүний эрх, эрх чөлөөг хангана.

5.4.3. Сумын төвийг камержуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.

5.4.4. Сумд эрх зүйн туслалцааны төвийг байгуулна.